

СОЁЛЫН ФИЛОСОФИЙН ЗАРИМ АСУУДАЛД

Ц.АЛТАНТУЯА
СУИС, НУ-ны тэнхим

Түлхүүр үг: Бүхэллэг шинж, утга санаа, оюун санаа, чөлөөт байдал, шинэ кантч үзэл, соёл, соёл иргэншил, үнэлэмж.

Товч утга: 1970-аад оны үед тэр үеийн ЗХУ-д хэвлэгдсэн эрдэм шинжилгээний томоохон бүтээл болох "Философская энциклопедия"-д соёлын философийг соёлын мөн чанар, утга учрыг ухамсарлах гэсэн утгаар өрнөдийн философид хэрэглэдэг ойлголт хэмээн тодорхойлсон байдаг. Үүнийгээ батлахын тулд энэхүү философийн чиглэлийн үндэс суурийг боловсруулсан философчид болох Вильгельм Виндельбанд, Эрнст Кассирер зэрэг шинэ кантч үзлийнхнийг ихээхэн жишээ татсан байдаг. Эдүгээ соёлын философи хэмээх энэхүү ойлголт нь философийн шинжлэх ухааны судлагдахууны хүрээнд хүндтэй байр эзэлж, энэ талын ном, бүтээл олноор хэвлэгдэх болов. Иймд соёлын философи гэгч чухам юу болох, түүний онцлогийн тухай зохиогч энэхүү өгүүлэлдээ авч үзэх зорилт тавьсан бөгөөд энэ сэдэвт холбогдох онолын баримтлалуудаас эл өгүүлэлд онцлон авч үзжээ.

Соёлын философийг үндэслэгчид хэмээн философийн түүхэнд зүй ёсоор тооцогддог Вильгельм Виндельбанд, Эрнст Кассирер нар өөрсдийн судалгаандаа соёлыг бие даасан бүхэл шинж чанар, соёлын утга санаа гэсэн үндсэн хоёр чиглэлээр авч үзсэн байдаг. Тухайлбал, Э.Кассирер "Ер нь оюуны соёл гэж юу вэ? Соёлын үйл ажиллагааны зорилго, чиглэл, утга санаа юуг илэрхийлдэг вэ?" гэсэн асуултыг тавиад "Соёлын бүхий л хэлбэрүүдийн гол зорилго бол сэтгэлгээ ба мэдрэхүйн түгээмэл ертөнц, хүнлэг шинжийн ертөнц, нэгдмэл сансар огторгуйг бүтээх явдал мөн. Бид одоо урлагийн бие даасан бүтээлүүд, шашны зан үйл болон домог зүйн сэтгэлгээг сонирхох хэрэггүй. Харин бид тэдгээрийг бүтээхэд шаардагддаг тэр хөдөлгөгч хүчийг л сонирхох хэрэгтэй. Хэрэв бид энэхүү их хүчний шинж чанарыг танин мэдэж, тэдгээрийг түүхэн үүслийнх нь үүднээс бус, харин бүтцийнх нь хувьд ойлгож, тэдгээрийн ялгаа юунд орших вэ, энэхүү ялгаа байгаа хэдий ч тэдний харилцан хамаарал хэрхэн илрэх вэ гэдгийг ойлгож чадах юм бол бид хүний соёлын шинж чанарын тухай шинэ мэдлэгийг олж авлаа гэсэн үг"¹ хэмээн хариулсан байна. Кассирерээс нилээд өмнө ХХ зууны эхэн үед В.Виндельбанд соёлын философийн тухай асуудлыг хөндөхдөө "сэтгэл зүйн анализ, социологийн харьцуулалт, түүхэн хөгжлийн генетик судалгаа нь цаг хугацаа, туршилтаас гадуур оюун санааны аливаа соёлын бүтээлд зуршмал байдаг тэр үндсэн бүтцийг илрүүлэх материал

¹ Кассирер Э. Избранное. Опыт о человеке. М., 1999. с 9.

болж өгсөн тохиолдолд л философи нь жинхэнэ ёсоор философи хэмээн нэрлэгдэх болно"² хэмээсэн байдаг.

Өөрөөр хэлбэл Виндельбанд болон түүнтэй санаа нэгт шинэ кантч үзлийнхэн утга санаа ба бүхэллэг шинж л соёлд оюун ухааныг өгдөг хэмээн үзсэн байна. Ингэснээр соёлын нэгдлийг олж авах, ойлгохын тулд Виндельбанд "өөрсдийн авч үзэж буй агуулга нь өөр хоорондоо ямар ч ялгаатай байсан хамаагүй аливаа соёлын үйл ажиллагааны бүхий л бие даасан хэсгүүдэд зуршмал байдаг тэр ерөнхий зүйлийг илэрхийлэгч үүргийн мөн чанарыг олж авах нь чухал бөгөөд энэ нь өөрийн судлах зүйлээ өөрөө буй болгож түүндээ өөрийн утга учрыг тогтоодог оюун санааны өөрийгөө ухамсарлахуйг илтгэх болно"³ гэж үзсэн байна. Оюун санааг авч үзэх шинэ кантч үзлийн мөн чанарыг авч үзэхдээ Кассирер оюун санааны үзэл баримтлалыг чөлөөт байдал, ёс суртахууны үзэл баримтлалтай холбон үзэж байв. Түүнийхээр "Кантын үзэж байгаагаар хүн төрөлхтөний тэмүүлж буй амжилтын гол, үндсэн зорилт болох асуултанд хариулт өгөхийн тулд хүний соёл иргэншлийн бий болгосон янз хэлбэрүүдийг нарийвчлан тайлбарлах шаардлагагүй юм. Энэ бол ёс суртахууны зорилт бөгөөд чухамдаа ёс суртахуунд, ёс зүйн тогтолцоонд л түүхийн философи ба иргэншлийн философийн жинхэнэ зарчмуудыг эрэлхийлэх шаардлагатай. Кантынхаар бол түүхийн философи ба соёлын философийн үндсэнд чөлөөт байдлын тухай үзэл санаа оршиж байдаг. Чөлөөт байдал гэдэг нь оюун санааны бие даасан шинж бөгөөд хүний оюун ухаан, зориг, хүслийн хөгжлийн явцад яаж, юуны тусламжтайгаар энэ бие даасан шинжийг олж авах вэ гэсэн асуудлыг шийдэхэд соёлын философийн түгээмэл зорилт нь оршдог"⁴ байна.

Эндээс шинэ кантч үзлийнхний соёлын философийг авч үзсэн чиг хандлагыг тодорхойлох боломж гарч ирдэг. Шинэ кантч үзлийнхэн янз бүрийн соёлын хэв маягийн тухай бус, харин Европийн соёлын тухай асуудалд анхаарлаа хандуулсан байна. Чухам энэ нөхцөл байдал л тэдний үзэл баримтлалыг ихээхэн хязгаарлагдмал шинжтэй болгож байгаа юм. Өөрийн харьяалагдаж буй соёлыг дотроос нь авч үзэн түүний хөгжлийг тодорхой чиглэлд хандуулах, боломжтой бөгөөд соёлын тухай асуудлыг объективаар авч үзэх боломжгүй юм. Учир нь түүнийг хөндлөнгөөс нь ажиглах боломжгүй гэсэн үг.

² Виндельбанд В. Философия в немецкой духовной жизни XX столетия. М., 1993. с 31

³ Мөн тэнд. с 34.

⁴ Кассирер Э. Избранное. Опыт о человеке. М., 1999. с 16.

Кантын хувьд европийн соёл гэдэг нь оюун ухаан, чөлөөт байдал, ёс суртахуунаар нөхцөлдсөн байдаг. Тэрээр энэхүү шинж чанарууд бүрэн давамгайлсан цагт хүн төрөлхтөн соёлын шинж байдлыг бүрэн эзэмшинэ гэж үзсэн байна. Мэдээж хэрэг түүх ба соёлд (зөвхөн европийн соёлд төдийгүй) үр ашигтай хөдөлгөгч хүч үйлчилж, чөлөөт байдал, ёс суртахуунд хандсан хандлага зонхилж байдаг. Гэхдээ соёлд зөвхөн ийм ухамсарлагдсан, оюунлаг хандлага давамгайлж байдаг хэмээн үзэх нь буруу юм. Учир нь эдгээр хандлагуудад өөр бусад хандлагууд сөрөн зогсож байдаг. Тухайлбал, оюун ухааны зэрэгцээ соёлд ухамсаргүй, урсгал үйл явцууд зэрэгцэн оршдог.

Үүнээс гадна шинэ кантч философчид философийн өөрийнх нь зорилго, мөн чанарыг өвөрмөцөөр ойлгож байв. Нэг талаас, тэд Аристотелийн нэг адил философийг сэтгэхүйн гол чиглүүлэгч, үнэний шинжийг илэрхийлэгч, мэдлэгийн түгээмэл утга учир хэмээн ойлгож байсан ба нөгөө талаас Кантын адилаар хүн төрөлхтөний оюунлаг, чиглүүлэгч бүтээгдэхүүн хэмээн ойлгож байв. Тухайлбал Э.Хуссерль "философ нь өөртөө голлох үүрэг, өөрийн өвөрмөц төгсгөлгүй зорилт болох нэг зэрэг бүхий л чин эрмэлзлийг хамаарч байдаг чөлөөтэй, түгээмэл ухамсарлалыг хадгалж байдаг"⁵ гэж бичсэн байна. Мөн соёл судлаач А.Швейцер "Өөрийн хамгийн дээд үүргийнхээ дагуу философи нь бидний оюун санааг ерөнхийд нь болон бүхэлд нь чиглүүлж байдаг удирдагч мөн"⁶ гэж бичсэн байдаг. Швейцерийн энэхүү тодорхойлолтод тулгуурлан Э.Кассирер бичихдээ "объектив, бүтээлч үнэнтэй адил ямар нэг зүйл бодит байдалд оршдог уу? өмнөх үеийнхэн маань ёс суртахуун ба хүнлэг чанарын идеал хэмээн нэрлэж байсан тийм зүйл байгаль дээр бий юу? Иймэрхүү асууултууд гарч ирсэн үед философ нь үүнийг хөндлөнгөөс ажиглаад байж болохгүй. Учир нь философийн өөрийнх нь дотоодод асар хүчтэй эрч хүч агуулагдаж байдаг. Чухамдаа философ нь ийм хүчийг цэврээр нь хадгалж байдаг учраас түүний тусламжтайгаар хүмүүсийн амьдрал, гадаад ертөнцөд зохих нөлөөллийг үзүүлж болно"⁷ гэсэн байна. Ингэснээр шинэ кантч үзлийнхэн үнэн хэрэгтээ соёлын философи л бидний оюун санааг чиглүүлэгч болохынхоо хувьд соёлыг аварч чадна гэж үзжээ.

Энэ бүхнийг авч үзсэний үндсэн дээр дүгнэж үзэх юм бол орчин үеийн философийн ухаан нь зөвхөн нэг бус харин олон төрлийн сэтгэхүйн

⁵ Гуревич П.С., Философия культуры. М., 2001. с. 42.

⁶ Мөн тэнд. с 42.

⁷ Кассирер Э. Избранное. Опыт о человеке. М., 1999. с 9.

хэлбэрүүдийг зөвшөөрөх шаардлагатай болсон юм. Гэхдээ философиин ухаан нь сэтгэхүйг цэгцэлж, зохистой байдалд оруулах үүргээсээ татгалзаагүй бөгөөд харин энэхүү зорилтоо өөр арга, замаар гүйцэлдүүлэх болсон байна. Тодорхой дүрэм, ахуйн нэгдмэл тогтолцоо бий болгохын оронд юуны өмнө үүсэн бий болсон соёлын харилцааг илүүтэй мөрдөж, түүний үндсэн тал, хүрээнүүдийг тооцон үзэх болов. Нөгөөтэйгүүр сэтгэхүйн үндсэн бүтцийг бий болгож, түүний хил, хязгаарыг тогтоох болсон байна.

Орчин үеийн философи нь хүний ахуй болон амьдралыг бүхэлд нь тодорхойлох гэсэн оролдлогоосоо татгалзах болжээ. Гэхдээ тэрээр амьдрал, ахуй ялангуяа сэтгэхүйн бүтцийн асуудалд өөрийн гэх хувь нэмрээ оруулсаар байна. Тэр ч бүү хэл шүүмжлэлт ба позитив ухамсарлал, үнэлэмжийн чиг баримжаа, сэтгэлгээний материалыг ойлголтын боловсруулах зэрэг асуудалд тэргүүлэх байр суурийг эзэлж байгаа юм. Нэрт философч Э.Хуссерль 1935 онд уншсан өөрийн алдарт илтгэлдээ "Философичийн онолын баримтлалд хамгийн чухлаар шаардагдах зүйл бол аливаа бэлэн санааг итгэл үнэмшил хэмээн үл үзэх өвөрмөц, түгээмэл шүүмжлэлт үзэл баримтлал байдаг"⁶ хэмээн бичсэн байна. Философи гэсэн ойлголтын олон талт агуулга нь түүний мөн чанарын өргөн цар хүрээ, түүхэн төлөвшлийн урт удаан хөгжил зэргээс үүдэлтэй. Гэхдээ л энэ ухагдахууныг өдөр дутмын амьдрал болон мэргэжлийн түвшинд хэрэглэх ялгаанаас үл хамааран тухайн ойлголтын цаана байгаль болон жирийн амьдралын үйл явдал болон байгалийн үзэгдлийг илтгэх ямар нэг мэдэрч, хүртэгдэх шинжүүдийг нэгтгэсэн нэгдмэл зарчим оршиж байдаг. Гэхдээ дэлхий нийтийн томоохон шинжлэх ухаан болох хувьдаа философи нь өөрийн эх сурвалжаараа эртний үед буюу эртний домоглол зүйд очиж хамаардаг.

Хүний гараар бүтсэн буюу байгалийн элдэв бүтээгдэхүүний мэдрэхүйгээр илрэгч зарчмын тухай яригдах үед сэтгэл хөдлөлийн мэдрэмж, сэтгэлийн догдлол, сонирхол зэргийг төрүүлдэг юмс үзэгдлийн байгууламжийн нэгдлийн тухай бид авч ярьдаг. Өөрөөр хэлбэл философийн шинжилгээний уламжлал төлөвшин тогтож эхэлсэн гэсэн үг юм. Ийнхүү философи эргэцүүллийн нэгэн судлах зүйл болдог дүрээр илрэгч ертөнцийн тухай (хүн болон байгалийн бүтээгдэхүүн) төсөөлөл бий болжээ.

Ингэснээр тэдгээрийн бүтэц, дотоод зохион байгуулалтын талаар идэвхитэй авч үзэн мэдрэхүйн шинжийг бэлэг тэмдгийн болон санаа бодлын агуулгатай холбох холбоо хамаарлыг тодорхойлж бодит байдлын үзэгдэл,

⁶ Гуревич П.С. Философия культуры. М., 2001. с. 42.

үйл явц дахь ухамсарлагдах болон үгээр үл илрэх шинжүүдийн харилцан хамаарлыг тогтоох оролдлого хийгдэх болов. Бодит байдлын шинж чанар болон түүнд тохирсон сэтгэл хөдлөлийн өрнөлтийг философи тулгуур категори болгох үнэний тухай ойлголтонд хамааруулах оролдлого хийгдэх болов.

Өөрөөр хэлбэл, философийг нэгэн томоохон байгууламж гэж үзэх юм бол түүний суурь нь үнэний тухай асуудал юм. Хэрэв сайн үйл гэдэг нь ёс зүйн категори, үнэн гэдэг нь шинжлэх ухааны тулгуур категори байдаг бол дээр дурьдагдсан философийн категорууд нь өөртөө ёс зүйн болон шашны утга агуулгыг шингээсэн "эрлийз" категорууд байдаг. Гэхдээ энд сэтгэл хөдлөлийн үйлдлийн тодорхой хэв шинжид тодорхой нэгэн ойлголтыг хамаатуулах нь бидний нүдний өмнө соёлын мөн чанарыг илэрхийлэгч ямар нэг хэв шинж байна гэсэн үг биш юм гэдгийг тэмдэглэх хэрэгтэй.

Аливаа мэдрэхүй бүр тэдний илэрхийлж буй агуулга зохих ёсоор хэлбэржин соёлын "хил хязгаарын" дотор үйлчилж, сэтгэл хөдлөлийн шинжүүд нь өөрийгөө соёлын өвөрмөц хэмжүүр бүхий бодит байдлын бүтээлээр дамжин илэрсэн нөхцөлд л философийн статусыг олдог байна. Үүнтэй нэгэн адилаар байгалийн үзэгдэл, үйл явц хүртэл үзэгдлийн араас мөн чанарыг илэрхийлдэг, гадна өнгө төрхийн араас бэлэг тэмдгийн агуулгыг илэрхийлдэг философийн зарчмаар үйлчилсэн тохиолдолд соёлын шинжийг илэрхийлэх чадвартай.

Соёлын илрэл бол бидний сэтгэл хөдлөлийг "хэлбэржүүлж" байдаг төсөөлөн бодохуй ба ой тогтоолт байдаг гэдгийг мартсанаараа сэтгэл хөдлөл ба соёл хоёрыг үргэлж адилтгадаг. "Болж өнгөрсөн бүхэн сайхан байдаг" гэсэн зүйр цэцэн үг нь соёлын философи бүрэлдэх механизмийг хамгийн тодорхой илэрхийлж байгаа юм. Судлаач М.М.Бахтин чухамдаа бидний ой тогтоолт л амьдралыг соёлын агуулгатай болгодог гэдгийг тэмдэглэсэн байна. Цаг хугацааны алслалт нь сэтгэл хөдлөлд төгс хэлбэрийг олгох ба өвөрмөц хэлбэрийн "мэдрэхүйн хадгалалт"-ыг бий болгодог. Харин энэ нь мэдрэхүй өөрөө бус харин зохистой бүхэллэг агуулга, илэрхийлэл буюу өөрөөр хэлбэл соёлын бүтэц бүхий зайлшгүй элементүүдтэй мэдрэхүйн тухай илэрхийлэл юм.

Гэхдээ асуудлын гол нь бодит сэтгэхүйн хүрээнд юуг авч үзэх ёстой вэ гэдэгт оршино. Тухайлбал, бидний үзэж байгаагаар орчин үеийн философчид аливаа нийгмийн үйл хөдлөл бүр бусад хүчнийхээ үйл хөдлөлийн хүрээнд хэрэгжиж байдаг гэдгийг тооцох хэрэгтэй. Өөрөөр

МУИС Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль

хэлбэл нийгмийн бичил орчинд оюун санаа үйлчилдэг төдийгүй урсгал зүйл 4ч үйлчилж байдаг. Иймэрхүү хандлагын хүрээнд соёлын философийн гүйцэтгэх үүрэг асар өндөрт тавигдаж байгаа юм. Өнөөдөр соёлын философи нь европын болон дэлхийн соёлыг аврахын тулд үйчлээгүй байна. Харин янз бүрийн соёл, тэдгээрийн үнэлэмжийг зөвшөөрөн хүлээж, тэдгээрийг судлах судалгааны түгээмэл аргыг боловсруулж байна.

Ийнхүү соёлын хөгжил нь философийг баяжуулагч онолын томоохон үзэл баримтлалууд цэцэглэн хөгжих үе шат бүхий эмпирик ажиглалтын урт хугацааны үеүдийн ээлж дараалсан хөгжлийг илэрхийлдэг. Соёлын хөгжлийн аль нэг салаа мөчир бүр тухайн эрин үе бүрийн философи сэтгэлгээний мөн чанарыг илэрхийлэх, түүний төсөөллийн чиг хандлага, зүй тогтлыг илрүүлэхэд чиглэгдэж байв. Энэ шалтгааны улмаас соёлын нэгтгэн дүгнэхүйн мөн чанар нь философи шинжтэй байдаг юм. Соёл нь өөрийн зохистой бүтцээ янз бүрийн үе шатны уран сайхны практик цогц шинжийнхээ, сонгомол болон олон түмний философи таашаалын хөгжлийн чиг хандлага, шалтгааныг ажигласаны үндсэн дээр төлөвшин тогтдог.

Соёлын хөгжлийг хүний харилцааны мөн чанарыг оюун ухааны тусламжтайгаар судлах буюу "гаднаас" нь судлах болон соёлын тодорхой үйл явцуудыг ухамсарласаны үр дүнд буюу "дотоос" нь судлах боломж нь нийгмийн үзэгдэл болохынх нь хувьд соёлд өөрийн гэх оршин тогтнох талбар байхгүй бөгөөд тэрээр тодорхой судалгааны талбаргүйн зэрэгцээ судлаачийн субъектив санаа зоригоос хамаарч өөрийн мөн чанарын агуулгаа үргэлж өөрчилж байдаг гэсэн болгоомжлол төрүүлэхэд хүргэсэн байна. Энэ үзлээр бол нэг талаас түгээмэл философийн шинжилгээнийнэг тал болдог, нөгөө талаасаа соёл судлалын цэвэр үр дүн болох соёл нь өөрийн гэх судалгааны талбаргүй болдог байна.

Мэдээж хэрэг нийгмийн үзэгдэл болох соёлын өвөрмөц шинж чанар нь түүний олон салбарыг нэгтгэн зангидсанд оршдог. Иймд соёлын тухай мэдлэгийг эзэмшихэд тохиолддог бэрхшээл нь тэрээр өөртөө "гал, ус хоёрыг нэгтгэсэн" байдагт оршино. Гэхдээ иймэрхүү "хэт туйлчилсан" шинж нь соёл нь ямар ч зохион байгуулалт, бүтэцгүй үзэгдэл гэсэн хэрэг биш юм. Соёл нь бидний хүрээлэн буй ертөнцийн илрэх хэлбэрийн мэдрэхүй дэх түгээмэл шинжийг илрүүлэхэд чиглэдэг. Өргөн утгаараа энэ нь соёлын бүтээл, уран сайхны үйл явц, төсөөллийн түгээмэл шинж, соёлын гадна орших уран сайхны үйл ажиллагааны түгээмэл шинж, ухамсрын төсөөлөл, байгалийн түгээмэл шинж юм.

Резюме

Изучение проблем культуры всегда было одним из главных направлений в мировой философской мысли. Но в рамках культуры существует целый ряд теорий, которые исследуют вопросы, связанные с сознанием. В данной статье исследуется спектр вопросов, касающихся взаимосвязи философии и культуры. Философские проблемы культуры связываются здесь в первую очередь с изменениями способов извлечения и обработки продуктов сознания, а эволюция культуры с применением особого рода деятельности, включающей в себе проблемы бытия.

Ашигласан ном зохиол

1. Э.А.Поздняков. Философия культуры. М.1999.
2. Кассирер Э. Избранное. Опыт о человеке. М., 1999.
3. Виндельбанд В. Философия в немецкой духовной жизни XX столетия. М., 1993.
4. Эволюция, культура, познание. М. 1996.
5. В.М.Розин. Культурология. М. 1999.
6. Гуревич П.С. Философия культуры. М., 2001.
7. П.С.Гуревич. Соёл судлал. I, II дэвтэр. УБ., 2004.